

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨВСГӨЛ НУУРЫН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ОРЧНЫ
БҮСИЙН ИРГЭДИЙН АМЬЖИРГААГ
ДЭМЖИХ, ТОГТВОРТОЙ АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
НЭГДСЭН ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
Э.САНСАРБАЯР ТАНАА

2020.04.24 № 00/1314
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирал Э.Сансарбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилчдын цалингаас нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцож тайлагнах, томилолтын зардлыг Сангийн сайдын тушаалын дагуу нормоор олгох, шатахуун зардлыг нормыг баримтлах, анхан шатны баримтын иж бүрдлийг хангуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн нэгжийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эйч Эл Би Монголиа” ХХК-ийн чанарын хяналтын менежер Х.Дорж, ахлах аудитор Т.Сугарсүрэн, аудиторын туслах П.Ганчимэг, Т.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эйч Эл Би Монголиа” ХХК-д 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 027/2020 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Байгальд ээлтэй тогтвортой хөгжил, Эдийн засгийн хүртээмжтэй өсөлтөд оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

- Хатгал, Ханх сууринд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэх
- Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар, орчны бүсэд мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, бэлчээрийн менежментийн чадавхыг бэхжүүлэх
- Нуурын орчимд хог хаягдлын менежментийг сайжруулах

Төслийн нийт санхүүжилт 3.2 сая ам доллар бөгөөд Хөвсгөл аймгийн Алаг Эрдэнэ, Ханх, Рэнчинлхүмбэ, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумд болон Хатгал тосгонд 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дөрвөн жилийн хугацаатай хэрэгжсэн.

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн удирдлага төсвийн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын хавсралт “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ritus” программ хангамж ашигладаг байна.

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар буюу 34,284.0 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд өөрчлөлт ороогүй болно. Материаллаг байдлын түвшинг 34,284.0 мянган төгрөгөөр тооцсон нь буцалтгүй тусламжаар орж буй мөнгөн хөрөнгийг зөв зохистой үр ашигтай зарцуулсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхтэй холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 223,681.7 мянган төгрөгөөр буюу 24.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	801,505.6	628,144.7	(173,360.9)
Үндсэн хөрөнгө	103,180.8	52,860.0	(50,320.8)
Нийт хөрөнгө	904,686.4	681,004.7	(223,681.7)
Өр төлбөр	4,549.7	18,392.9	13,843.2
Хуримтлагдсан үр дүн	900,136.7	662,611.8	(237,524.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	904,686.4	681,004.7	(223,681.7)

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд тооцсон элэгдлээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 13,843.2 мянган төгрөгөөр өссөн нь санхүүжилт хугацаандаа орж ирээгүй шалтгаанаас 2019 оны жилийн эцсийн ХХОАТ-ын 11,912.8 мянган төгрөг, цалингийн 6,480.0 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 2,376,400.0 мянган төгрөгийн батлагдсанаас гүйцэтгэлээр 2,146,306.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 90.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Нийт орлогын батлагдсан төсөв, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	97,400.0	95,812.9	1,587.1	98.2
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	2,270,000.0	2,050,493.4	(219,506.5)	90.3
Нийт дүн	2,376,400.0	2,146,306.3	(221,093.6)	90.3

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн үйл ажиллагаанд зориулан 2,367,400.0 мянган төгрөгийн төсвийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Хүснэгт 3. Төсвийн зарцуулалт

/мянган төгрөг/

Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Байр ашиглалттай холбоотой зардал	19,809.0	19,314.8	494.1	97.5
Хангамж, бараа материалын зардал	55,270.4	54,436.2	834.1	98.5
Томилолт, зочны зардал	10,220.6	10,010.4	210.2	97.9
Бусдаар гүйцэтгүүлэх	2,270,000.0	2,194,342.3	75,657.7	96.6
Бараа үйлчилгээний бусад зардал	12,100.0	12,051.3	48.6	99.6
Нийт дүн	2,367,400.0	2,290,155.2	77,244.8	96.7

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,290,155.2 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4 алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж өглөө.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төслийн үйл ажиллагааны буцалтгүй тусламжийн санхүүжилтийн үлдэгдэл 628,144.7 мянган төгрөгийн зарцуулалтанд хяналт тавих.

2.12. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт болон бусад гэсэн мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж өгснөөс, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

2.14. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Төслийн нэгжийн хөдөө орон нутагт ажилласан 9,608.5 мянган төгрөгийн томилолтын зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тооцож хянадаггүй. Сангийн сайдын 2018 оны “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 301 дүгээр тушаалыг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл: Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь томилолтын зардал буруу дүнгээр илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Томилолтын зардлыг Сангийн сайдын 2018 оны “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 301 дүгээр тушаалын дагуу тооцож, гүйцэтгэлд хяналт тавих,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх 5,692.2 мянган төгрөгийн автомашины шатахууныг нормоор тооцож олгоогүй, зарцуулалтанд хяналт тавьдаггүй.

3.2.2 Эрсдэл: Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь шатахууны зардал буруу дүнгээр илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Дэд бүтцийн сайдын 2004 оны “Жишиг норм батлах тухай” 19 дүгээр тушаалын дагуу шатахууны нормыг баримталж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.3 Цалингийн данстай холбоотой асуудал

- 3.3.1 Илрүүлэлт: Төслийн нэгжийн ажилтнуудад олгосон цалингаас ажил олгогч болон даатгуулагчийн НДШ суутгаагүй зөвхөн ХХОАТ суутган тооцож цалинг олгосон. Энэ нь “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 2-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;” заавал даатгуулна гэсэн заалттай нийцэхгүй байна.
- 3.3.2 Эрсдэл: Төслийн нэгжийн ажилтнуудын цалингаас НДШ суутгагдахгүй байгаагаас ажилтны төсөлд ажилласан хугацаа, авсан цалин нотлогдохгүй, эрүүл мэнд, нийгмийн даатгалын хөнгөлөлт, үйлчилгээ авч чадахгүй байх.
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: Ажилтнуудын цалингаас НДШ-ийг суутган, холбогдох тооцоог нийгмийн даатгалын байгууллагатай хийх;
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.4 Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу

- 3.4.1 Илрүүлэлт: Төслийн үйл ажиллагааны 10,041.9 мянган төгрөгийн зардлуудын анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалтыг бүрэн хангаж ажиллаагүй.
- 3.4.2 Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн хууль, журам зөрчигдөх. Мөнгөний зүй бус зарцуулалт гарах.
- 3.4.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт заалтын 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
- 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	801,505,569.43	628,144,680.18
МӨНГӨН ХӨРӨНГӨ	801,505,569.43	628,144,680.18
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Төгрөг	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	801,505,569.43	628,144,680.18
Төрийн сангийн харилцах	27,628,196.03	-
Арилжааны банк дахь харилцах	226,961,155.26	104,033,140.97
Арилжааны банк дахь валют харилцах	546,916,218.14	524,111,539.21
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	103,180,840.01	52,860,035.83
Биет хөрөнгө	99,434,498.54	52,860,035.83
Авто-тээврийн хэрэгсэл	102,800,000.00	102,800,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(32,888,888.89)	(50,022,222.23)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	51,837,840.00	52,118,900.00
Хуримтлагдсан элэгдэл	(32,931,564.21)	(52,036,641.94)
Тавилга, аж ахуйн эд хогшил	25,320,760.00	25,039,700.00
Хуримтлагдсан элэгдэл	(14,703,648.36)	(25,039,700.00)
Биет бус хөрөнгө	3,746,341.47	-
Програм хангамж	12,800,000.00	12,800,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(9,053,658.53)	(12,800,000.00)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	904,686,409.48	681,004,716.01
НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,549,677.87	18,392,865.26
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,549,677.87	18,392,865.26
Ажилчидтай холбогдсон өглөг	4,549,677.87	18,392,865.26
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	900,136,732.61	662,611,850.75
Засгийн газрын хувь оролцоо	-	-
Хуримтлагдсан үр дүн	900,136,731.61	662,611,850.75
Өмнөх үеийн үр дүн	1,520,379,379.02	900,136,731.61
Тайлант үеийн үр дүн	(620,242,647.41)	(237,524,880.86)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	904,686,409.48	681,004,716.01

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,534,096,490.38	2,156,614,304.56
ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,534,096,490.38	2,059,214,304.56
Нийтлэг татварын бус орлого	1,416,265,828.22	8,720,860.03
Хувьцааны ногдол ашиг	-	-
Хүүгийн орлого	-	8,720,860.03
Тусламжийн орлого	1,416,265,828.22	2,050,493,444.53
Хандив тусламж /дотоод/	-	-
Хандив тусламж /гадаад/	1,416,265,828.22	2,050,493,444.53
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,399,800	97,400,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	97,399,800	97,400,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	97,399,800	97,400,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,149,647,236.59	2,392,255,342.15
УРСГАЛ ЗАРДАЛ	2,149,647,236.59	2,392,255,342.15
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,149,647,236.59	2,363,040,048.07
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	509,214,055.73	-
Үндсэн цалин	309,214,055.73	-
Гэрээт ажлын хөлс	200,000,000.00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,536,897.29	19,314,888.00
Гэрэл, цахилгаан	1,590,000.00	-
Түлш, халаалт	17,946,897.29	609,000.00
Байрны түрээс	-	18,705,888.00
Хангамж, бараа материалын зардал	43,432,089.60	54,436,250.31
Бичиг хэрэг	6,001,986.00	6,352,072.18
Тээвэр, шатахуун	27,600,000.00	30,250,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,438,613.60	6,631,741.40
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,052,000.00	6,351,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,339,490.00	4,851,436.73
Томилолт, зочны зардал	5,856,500.00	10,010,400.00
Гадаад албан томилолт	-	-
Дотоод албан томилолт	5,856,500.00	10,010,400.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	914,013,649.72	2,216,906,341.94
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	913,655,442.02	2,208,185,506.69
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	358,207.70	-
Бусад зардал	-	8,720,835.25
Бараа үйлчилгээний бусад зардал	657,594,044.25	62,372,167.82
Бараа үйлчилгээний бусад зардал	614,410,529.83	12,051,363.64
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,183,514.42	50,320,804.18
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	29,215,294.08
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,587,098.05

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төвлөрүүлэх шилжүүлэг	-	27,628,196.03
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(615,550,746.21)	(235,641,037.59)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	7,119,985.58
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	7,119,985.58
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,003,828.85
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	4,691,901.20	9,003,828.85
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(620,242,647.41)	(237,524,880.86)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,417,526,851.78	2,156,614,304.56
Тусламжийн орлого	1,416,265,828.22	2,059,214,304.56
Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	8,720,860.03
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,720,860.03
Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	-
Хандив тусламж /гадаад/	1,416,265,828.22	2,050,493,444.53
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,399,800.00	97,400,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	97,399,800.00	97,400,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	97,399,800.00	97,400,000.00
Бараа ажил үйлчилгээний орлого	903,861,223.56	-
Зээлийн эргэлтийн сангийн санхүүжилт	903,861,223.56	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,149,647,236.59	2,328,091,350.54
УРСГАЛ ЗАРДАЛ	2,149,647,236.59	2,328,091,350.54
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,149,647,236.59	2,298,876,056.46
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	509,214,055.73	-
Цалин	509,214,055.73	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,536,897.29	19,314,888.00
Түлш, халаалт	1,590,000.00	609,000.00
Байрны түрээс	17,946,897.29	18,705,888.00
Хангамж, бараа материалын зардал	43,432,089.60	54,436,250.31
Бичиг хэрэг	6,001,986.00	6,352,072.18
Тээвэр, шатахуун	27,600,000.00	30,250,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,438,613.60	6,631,741.40
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,052,000.00	6,351,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,339,490.00	4,851,436.73
Томилолт, зочны зардал	5,856,500.00	10,010,400.00
Дотоод албан томилолт	5,856,500.00	10,010,400.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	914,013,649.72	2,194,342,319.26
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	913,655,442.02	2,194,342,319.26
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	358,207.70	-
Бараа үйлчилгээний бусад зардал	657,594,044.25	12,051,363.64
Бараа үйлчилгээний бусад зардал	614,410,529.83	12,051,363.64
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	43,185,514.42	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	37,986,129.33
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	37,986,129.33
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,587,098.05
Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	36,349,031.28
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	267,879,615.19	(171,477,045.98)

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(837,266,502.82)	(1,883,843.27)
Бусад эх үүсвэр	(832,574,601.62)	7,119,985.58
Хүүгийн орлого	20,430,862.16	-
Зээл олголт	(1,011,253,979.00)	-
Зээл төлөлт	158,248,515.22	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	7,119,985.58
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	(4,691,901.20)	9,003,828.85
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(4,691,901.20)	9,003,828.85
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	267,879,615.19	(173,360,889.25)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,370,892,457.06	801,505,569.43
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	801,505,569.43	628,144,680.18

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	900,136,731.61	900,136,731.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(237,524,880.86)	(237,524,880.86)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	662,611,850.75	662,611,850.75

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,367,400,000.00	2,290,155,221.21	77,244,778.79	96.7
УРСГАЛ ЗАРДАЛ	2,367,400,000.00	2,290,155,221.21	77,244,778.79	96.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,367,400,000.00	2,290,155,221.21	77,244,778.79	96.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,809,000.00	19,314,888.00	(494,112.00)	97.5
Түлш, халаалт	609,000.00	609,000.00	-	100
Байрны түрээс	19,200,000.00	18,705,888.00	(494,112.00)	97.4
Хангамж, бараа материалын зардал	55,270,400.00	54,436,250.31	(834,149.69)	98.5
Бичиг хэрэг	6,358,000.00	6,352,072.18	(5,927.82)	99.9
Тээвэр, шатахуун	30,272,400.00	30,250,000.00	(22,000.00)	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,780,000.00	6,631,741.40	(148,258.60)	97.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,360,000.00	6,351,000.00	(9,000.00)	99.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.00	4,851,436.73	(648,563.27)	88.2
Томилолт, зочны зардал	10,220,600.00	10,010,400.00	(210,200.00)	97.9
Гадаад албан томилолт	-	-	-	-
Дотоод албан томилолт	10,220,600.00	10,010,400.00	(210,200.00)	97.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,270,000,000.00	2,194,342,319.26	(75,657,680.74)	96.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,270,000,000.00	2,194,342,319.26	(75,657,680.74)	96.7
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-	-	-
Бараа үйлчилгээний бусад зардал	12,100,000.00	12,051,363.64	(48,636.36)	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	12,100,000.00	12,051,363.64	(48,636.36)	99.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,367,400,000.00	2,146,306,346.48	(221,093,653.52)	90.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	97,400,000.00	95,812,901.95	(1,587,098.05)	98.4
Улсын төсвөөс санхүүжих	97,400,000.00	95,812,901.95	(1,587,098.05)	98.4
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-	-	-
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	2,270,000,000.00	2,050,493,444.53	(219,506,555.47)	90.3
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	2,270,000,000.00	2,050,493,444.53	(219,506,555.47)	90.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	801,505,569.43		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	628,144,680.18		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
Байгууллагын тоо	1	1		
Ажиллагсдын тоо	12	12		
Удирдах ажилтан	3	3		
Гүйцэтгэх ажилтан	9	9		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020/04/14	Аудитын нэр: ХНБЦГОБИАДТАЖХ нэгдсэн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/748/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төслийн нэгжийн хөдөө орон нутагт ажилласан томилолтын зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тооцож хянаагүй.	9.6	Зөвлөмж өгөх	Төслийн менежер, Төслийн нягтлан бодогч	Т.Эрдэнэжаргал, Э.Замбага
2	Төслийн нэгжийн ажилтнуудад олгосон цалингаас ажил олгогч болон даатгуулагчийн НДШ суутгаагүй зөвхөн ХХОАТ суутган тооцож цалинг олгосон.	-	Зөвлөмж өгөх	Төслийн менежер, Төслийн нягтлан бодогч	Т.Эрдэнэжаргал, Э.Замбага
3	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх автомашины шатахууныг нормоор тооцож олгоогүй, зарцуулалтанд хяналт тавьдаггүй.	5.7	Зөвлөмж өгөх	Төслийн менежер, Төслийн нягтлан бодогч	Т.Эрдэнэжаргал, Э.Замбага
4	Төслийн үйл ажиллагааны зардлуудын анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалтыг бүрэн хангаж ажиллаагүй.	10.0	Зөвлөмж өгөх	Төслийн менежер, Төслийн нягтлан бодогч	Т.Эрдэнэжаргал, Э.Замбага

